

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН ШИЛДЭГ СУРАЛЦАГЧ, АНГИ, ХАМТ ОЛОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Нэг . Нийтлэг үндэслэл

- 1.1. Сургуулийн сурлага, урлаг спортын чиглэлээр олон улсын болон улс, бүс нутгийн уралдаан тэмцээнд оролцох болзол хангаж, амжилт гаргасан суралцагчид, анги хамт олонд дэмжлэг үзүүлэхэд энэхүү журмыг үндэслэнэ.
- 1.2. Сургуулийн дотоод журмыг чандлан биелүүлсэн нийгмийн идэвх санаачилгасайтай сурлага урлаг спортын өндөр амжилт гаргасан болон олон нийтийн ажилд идэвхтэй оролцдог тэргүүний суралцагч, шилдэг анги хамт олныг сонгон шалгаруулна.

Хоёр. Шилдэг суралцагч, шилдэг анги, хамт олныг шалгуулах үзүүлэлт

- 2.1. Сургуулийн сурлагаар тэргүүлсэн суралцагчийг шалгаруулах шалгуур үзүүлэлт
 - 2.1.1. Сурлагын үзүүлэлт 85 хувиас дээш байх
 - 2.1.2. Хоёроос дээш улирал амжилттай суралцсан байх
 - 2.1.3. Олимпиад уралдаан тэмцээнд оролцсон байх
 - 2.1.4. Бусдад тусалж, суралцагчийн үүргийг нэр хүндтэй биелүүлсэн байдал
 - 2.1.5. Номтой нөхөрлөж, уншиж мэдсэнээ бусдад түгээн дэлгэрүүлсэн байх
 - 2.1.6. Олон нийтийн ажилд идэвх, санаачилга гарган бусдыгаа манлайлан оролцдог байх.
 - 2.1.7. Өөрийн бүтээлч сэтгэлгээг хөгжүүлж, шинэ бүтээл, оновчтой санал гарган хийж бүтээсэн зүйлээрээ үзэсгэлэн гаргах
 - 2.1.8. Байгалийн гамшигт үзэгдэл, онцгой эрсдэлтэй нөхцөлд үе тэнгийнхнийг ээуриалан тусалж, онцгой сайн үйлс бүтээсэн байх
 - 2.1.9. Хүүхдийн өөрөө удирдах байгууллага, сургуулийн дэргэдэх клубын гишүүн, идэвхтэн байх
 - 2.1.10. Өөрийн сонгон суралцаж байгаа мэргэжлийн аюулгүй ажиллагааны дүрэм, журмыг мөрдөн ажилладаг байх
- 2.2. Сургуулийн урлагийн тэргүүний суралцагчийг шалгаруулах шалгуур үзүүлэлт
 - 2.2.1. Өөрийн сонирхсон урлагийн төрлөөр олон жил тасралтгүй хичээллэсэн байх
 - 2.2.2. Урлагийн наадам болон сургуулиас зохион байгуулж буй соёл хүмүүжлийн ажилд идэвх санаачлагатай оролцсон байх
 - 2.2.3. Соёл урлагийн уралдаан тэмцээнд амжилттай оролцож, эхний 3 байрт шалгарсан байх
 - 2.2.4. Улс, бүс аймгийн уралдаан тэмцээнд оролцож амжилт үзүүлсэн байх
 - 2.2.5. Эх орныхоо түүх, соёлын өв уламжлалаас суралцсан ба энэ талаар үе тэнгийнхнийхээ дунд түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулсан байх
 - 2.2.6. Хүүхдийн өөрөө удирдах байгууллага, сургуулийн дэргэдэх клубын гишүүн, идэвхтэн байх
 - 2.2.7. Бусдад тусалж, суралцагчийн үүргийг нэр хүндтэй биелүүлсэн байх
- 2.3. Сургуулийн спортын тэргүүний суралцагчийг сонгон шалгаруулах шалгуур үзүүлэлт
 - 2.3.1. Өөрийн сонирхсон спортын төрлөөр тууштай хичээллэж өөрийгөө хөгжүүлсэн байх
 - 2.3.2. Аймаг, улс, бүсийн уралдаан тэмцээнүүдэд оролцож өндөр амжилт гарган цол зэрэг хүртсэн байх
 - 2.3.3. Хүүхдийн өөрөө удирдах байгууллага, сургуулийн дэргэдэх клубын гишүүн, идэвхтэн байх

- 2.3.4 Бусдад тусалж, суралцагчийн үүргийг нэр хүндтэй биелүүлсэн байдал
- 2.3.5 Өөрийн сонгон суралцаж байгаа мэргэжлийн аюулгүй ажиллагааны дүрэм, журмыг мөрдөн ажилладаг байх
- 2.4 Мэргэжлийн ур чадвар, бүтээлийн тэргүүний суралцагчийг сонгон шалгаруулах шалгуур үзүүлэлт
- 2.4.1 Мэргэжлийн ур чадвар, илтгэл, олимпиад уралдаан тэмцээнд оролцонолон улс, бүс, аймгийн хэмжээнд амжилт үзүүлсэн байх
- 2.4.2 Сургуулийн болон захирлын нэрэмжит ур чадварын уралдаан, мэргэжлийн бүтээлийн уралдаанд амжилт үзүүлсэн болон оролцсон байх
- 2.4.3 Суралцаж байх хугацаандаа бизнесийн гараагаа эхэлж төсөл хөтөлбөрт хамрагдсан байх
- 2.4.3 Бусдад тусалж, суралцагчийн үүргийг нэр хүндтэй биелүүлсэн байдал
- 2.4.5 Өөрийн сонгон суралцаж байгаа мэргэжлийн аюулгүй ажиллагааны дүрэм, журмыг мөрдөн ажилладаг байх
- 2.5 Шилдэг анги, хамт олон шалгаруулах шалгуур үзүүлэлт
- 2.5.1 Анги хамт олны сурлагын чанар 80-аас дээш хувьд хүрсэн байх
- 2.5.2 Мэргэжлийн болон бусад чиглэлээр уралдаан тэмцээнд амжилттай оролцож, сургуулийн нэрийг гаргасан байх
- 2.5.3 Тус сургуулиас зохион байгуулагдсан урлаг, спорт, танин мэдэхүйн арга хэмжээнүүдэд тухайн хичээлийн жилийн турш анги хамт олноороо идэвхтэй оролцож, тодорхой амжилт гаргасан байх
- 2.5.4. Сургуулийн дотоод дүрэм, журмыг мөрдлөг болгон суралцаж ёс зүйтэй хамт олон болсон байх
- 2.5.6 Анги, хамт олноороо нийгэм, олон нийтийн үйл ажиллагааг санаачлан, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж ажилласан байх
- 2.5.7 Шинэ санаа дэвшүүлдэг, бүтээлч суралцагчийн эзлэх хувь өндөр байх
- 2.5.7 Сургуулийг хөгжүүлэх үйлсэд анги хамт олноороо санаачилга гарган бүтээн байгуулалтын ажил хийсэн байх
- 2.5.8 Сургалтын орчныг сайжруулахад идэвх санаачлагатай оролцож эко орчныг бүрдүүлэх
- 2.5.9 Анги хамт олноороо амжилттай сайн суралцаж, сургуулиас зохион байгуулагдсан мэргэжлийн ур чадвар, хөгжүүлэх уралдаан тэмцээнд идэвхтэй оролцож зохих амжилт гаргасан, нийгэм, олон нийтийн үйл ажиллагаанд идэвх, санаачлагатай оролцдог
- 2.5.10 Анги хамт олон нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм журмыг мөрдөн ажиллаж бусдад түгээн дэлгэрүүлэх нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж ажилласан байх.

Гурав. Зохион байгуулалт

3.1. Сургуулийн шилдэг суралцагч, шилдэг анги, хамт олны тодорхойлолтыг анхан шатны байгууллага болон анги хамт олон, ангийн багшийн тодорхойлолтыг үндэслэн нийгмийн ажилтнууд хүлээн авч, сургалтын албаны хурлаар хэлэлцүүлэн тухайн хурлаас гарсан шийдвэрийг үндэслэн шалгаруулна.

Дөрөв. Шагнал урамшуулал

- 4.1 Тухайн жил сонгон шалгарсан шилдэг суралцагчид медаль, батламж ивээн тэтгэгч байгууллагын шагнал, шилдэг анги хамт олонд батламж, ивээн тэтгэгч байгууллагын шагналаар урамшуулна.
- 4.2 Шагнал авсан анги хамт, суралцагчдыг олон нийтийн хэвлэл мэдээлэл, хүндэт самбар, цахим хуудсаар сурталчилж өсвөр үеийнхэнд үлгэр дуурайлал болгон алдаршуулна.